


Аймгийн Засаг даргын 2022 оны
 05 дугаар сарын ...-ны өдрийн
 1137 дугаар захирамжийн
 ... дугаар хавсралт



ЗАРДЛЫН ТООЦОО

Д/Д	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Тооллогын сурталчилгаа	Телевиз, сонин, хэвлэл	Контент, сонин, хэвлэсэн материалын тоогоор	-	502,260
2	Нэмэлт тоологчийн зардал	Хүн	10	265,000	2,650,000
3	Маягт хэвлэх зардал зардал	ш	200	1,250	250,000
4	Шатахууны зардал	л	242	2,470	597,740
Нийт дүн					4,000,000

Аймгийн Засаг даргын 2022 оны
... дугаар сарын ...-ны өдрийн
... дугаар захирамжийн
... дүгээр хавсралт

**ХӨДӨӨ АЖ АХУЙН 2022 ОНЫ ЭЭЛЖИТ ТООЛЛОГЫГ
ЗОХИОН БАЙГУУЛЖ ЯВУУЛАХ АЙМГИЙН КОМИССЫН
БҮРЭЛДЭХҮҮН**

Комиссын дарга: И.Доржсүрэн (аймгийн Засаг даргын орлогч)

Орлогч дарга: О.Түмэнжаргал (аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн дарга)

Гишүүд: С.Цэдэнбалжир (аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)

Б.Цэнгэл (аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мал үржлийн албаны дарга)

Ю.Ганхуяг (аймгийн Засаг даргын дэргэдэх Байгаль орчин, аялал жуучлалын газрын Ойн нэгжийн дарга)

Н.Алтанцэцэг (аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газрын Газар тариалан хариуцсан мэргэжилтэн)

С.Аравзайлхам (аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Суурь судалгаа, газрын мониторинг хариуцсан мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: Н.Даваатогтох (аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн Хөдөө аж ахуй хариуцсан мэргэжилтэн)

-оОо-



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2022 оны 03 сарын 03 өдөр

Дугаар А/137

Арвайхээр

**Хөдөө аж ахуйн ээлжит тооллогын комиссын
бүрэлдэхүүнийг томилох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Статистикийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн "л", Засгийн газрын 2022 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн "Хөдөө аж ахуйн ээлжит тооллого явуулах тухай" 74 дүгээр тогтоол, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дугаар заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1.Хөдөө аж ахуйн 2022 оны ээлжит тооллогыг зохион байгуулж явуулах аймгийн комиссыг 1 дүгээр хавсралтаар, холбогдох 4,000,000 (дөрвөн сая) төгрөгийн зардлыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Хөдөө аж ахуйн тооллогын бэлтгэл, зохион байгуулалтын ажлыг аймгийн түвшинд хангаж, тооллогыг тогтоосон хугацаанд заавар, журмын дагуу чанартай явуулж, дүнг нэгтгэн танилцуулахыг Зохион байгуулах комисс (И.Доржсүрэн)-д даалгасугай.

3.Тооллогын ажлыг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах Ажлын хэсгийг байгуулан, хөдөө аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг өрх, аж ахуйн нэгжийг тооллогод бүрэн хамруулж, тооллогын үйл ажиллагаанд хяналт тавин, дүн мэдээг нэгтгэж, аймгийн комисст 2022 оны 07 дугаар сарын 04-ний дотор хүлээлгэн өгөхийг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4.Дээрх зардлыг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Ганболд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6222 11 0285